

Юнити Ассет Менежмент ХХК-ийн ТУЗ-ийн
2022 оны 5-р сарын 19-ний өдрийн 22/05-01
тоот тогтоолын ХХ...-р хавсралт



ЮНИТИ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ УДИРДЛАГЫН БОДЛОГО

1. ЗОРИЛГО

1.1. Юнити ассет менежмент ҮЦК ХХК-ийн Байгаль орчны удирдлагын бодлогын зорилго нь бусад оролцогч талууд (компанийн ажилтан, гэрээт ажилчид, хөрөнгө оруулагч, харилцагчид үүгээр зөвхөн хязгаарлагдахгүй)-ын аливаа төсөл хөтөлбөр, үйл ажиллагааны Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг дэмжин ажиллахад оршино.

2. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

2.1. Юнити ассет менежмент ҮЦК ХХК нь оролцогч талуудын ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлж, тэдгээрийг зохистойгоор тэнцвэржүүлэн ажиллахдаа Байгаль орчин, нийгэм эдийн засаг, засаглалын тогтвортой хөгжлийг дэмждэг тул компанийн бүх үйл ажиллагаандаа байгаль орчны хариуцлагатай бодлого баримтална. Иймээс бид үйл ажиллагаандаа дараах зарчмыг мөрдлөг болгоно. Үүнд:

- 2.1.1. Байгаль орчны тухай бүхий л холбогдох хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ тодорхойлж, мөрдөж ажиллана.
- 2.1.2. Хүлэмжийн хий, хог, химийн хаягдал, агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах, дуу чимээ, доргио чичиргээг багасгаж удирдах зэрэг байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаанд сангийн хөрөнгийг байршуулахыг эрмэлзэнэ.
- 2.1.3. Компанийн үйл ажиллагаандаа эрчим хүчний эх үүсвэр, материал нөөцийг ариг гамтай ашиглаж, хэмнэхээс гадна сангийн хөрөнгө оруулалтыг эрчим хүчний нөөцийг үр ашигтай ашиглах технологи бүхий үйл ажиллагаа төсөл хөтөлбөрт байршуулахыг дэмжинэ.
- 2.1.4. Компаний ажилтнуудын байгаль орчны хүрээнд хүлээсэн үүргээ бодитоор ухамсарлан ойлгоход тусалж, сургалт явуулна.
- 2.1.5. Байгаль орчны зорилтуудаа хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг төлөвлөж, хэрэгжилтийг хангана.